

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

**АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ**

ХУРЛЫН ТОВХИМОЛ 2026

ALWAYS FORWARD

АГУУЛГА

ХУРАЛД ОРОЛЦОХ ТОВЧ ЗААВАР	4
ХУРЛЫН ДЭГ	5
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	6
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1	7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ	
ГОЛЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ	8
НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ	9
ТУЗ-ИЙН АЖЛЫН ТАЙЛАН	10
АПУ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ	12
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2	13
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3	14
НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ	
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4	17
ҮНДЭСЛЭЛ	
ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ	18
САНАЛЫН ХУУДСЫН ЗАГВАР	20
ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ	21



АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн хурлын 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн 26/03 тоот тогтоолоор Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 22-ны өдрийн 14:00 цагт цахимаар зохион байгуулах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. Компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. Компанийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох,
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр:
2026 оны 04-р сарын 02-ний өдөр

Хувьцаа эзэмшигч та бүхэн:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын <https://www.agm.mn/> цахим хуудсанд хурлын бүртгэлийн өдрөөс хойш бүртгүүлж, хуралд цахимаар оролцоно.
2. Харилцагч брокер дилерийн компани эсхүл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот, Утас: 7555-1919 /4/, 99043165)-д ажлын өдөр, ажлын цагаар очиж, санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар санал авах хугацаа 2026 оны 04 сарын 21-ний өдрийн 18:00 цагт дуусна.

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утас, цахим хаягаар ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд холбогдож авна уу.

№	Нэрс	Утас	Имэйл хаяг	Цахим хуудас
1	Комиссын дарга: Б.Сарантунгалаг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)			
2	Гишүүд: Б.Мягмар (ТУЗ-ийн ажлын алба) Э.Солонго (Хууль, ТУЗ-ийн ажлын алба) Д.Баясгалан (Дижитал технологийн алба) Н.Халиунаа (Байгууллагын харилцааны алба)	11-344336	agm@apu.mn	www.apu.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

АПУ ХК, Чингисийн өргөн чөлөө-14, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17040, Монгол Улс



ХУРАЛД ОРОЛЦОХ ТОВЧ ЗААВАР

Хувьцаа эзэмшигч та дараах хоёр аргын аль нэгээр хуралдаа оролцож, санал өгөх боломжтой.

Цахимаар оролцох заавар	Саналын хуудсаар оролцох заавар
1. Хурлын бүртгэлийн өдөр буюу 2026.04.02-ны өдрөөс хойш www.agm.mn цахим хуудсаар бүртгүүлэх эсхүл E-Mongolia-д нэвтэрдэгтэй адил ДАН системийг ашиглан нэвтэрнэ.	1. Харилцагч брокер дилерийн компани эсхүл хурлын тооллогын комисс БиДиСек ҮЦК ХК (Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот, Утас: 7555-1919 /4)-тай холбогдож, 2026.04.21-ний өдрийн 18:00 цагаас өмнө санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой.
2. Хурал 2026.04.22-ны өдрийн 14:00 цагт эхлэх ба өөрийн урьдчилан бүртгүүлсэн нэвтрэх нэр, нууц үгээр эсхүл ДАН системийг ашиглан нэвтэрч, хуралд цахимаар оролцон, санал хураалтын үед цахимаар саналаа өгнө.	2. Харилцагч брокер нь хувьцаа эзэмшигчийн бөглөсөн саналын хуудсыг гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан, Хурлын тооллогын комисст хүргүүлснээр хувьцаа эзэмшигчийн ирц бүртгэгдэж, санал хүргэгдэнэ.

Асууж тодруулах зүйл байвал хурал зохион байгуулах комиссын 11-344336 утас, agm@aru.mn имэйл хаягаар холбоо барина уу.



ХУРЛЫН ДЭГ

Хурал 2026 ны 04 сарын 22-ны өдрийн 14:00 цагт эхэлж, 15:15 цагт дуусна.

№	Үйл ажиллагаа	Шийдвэрийн төрөл	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын зохион байгуулалтыг танилцуулах		14:00–14:02	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
2	Бүртгэлийн ажиллагааны дүнг гарган, танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	14:02–14:05	Тооллогын комисс
3	Хурлыг нээж, АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах		14:05–14:20	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
4	2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайланг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:20–14:30	ТУЗ-ийн хараат бус гишүүн
5	Асуулт, хариулт		14:30–14:35	
6	ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:35–14:38	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
7	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:38–14:45	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
8	Асуулт, хариулт		14:45–14:50	
9	ТУЗ-ийн цалин урамшууллын талаарх мэдээллийг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:50–14:53	ТУЗ-ийн хараат бус гишүүн
10	Асуулт, хариулт		14:53–14:58	
11	Цахимаар санал өгөх зааврыг танилцуулах		14:58–15:00	Тооллогын комисс
12	Хэлэлцэх асуудлуудаар санал хураалт явуулах		15:00–15:05	Тооллогын комисс
13	Санал хураалтын дүн гаргаж, хуралд оролцогчдод танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	15:05–15:10	Тооллогын комисс
14	Хурлыг хаах		15:10–15:15	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг



ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ


1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох,
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.




ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1

АПУ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ


Цэвэр борлуулалтын орлого
/тэрбум төгрөг/




Үйл ажиллагааны ашиг
/тэрбум төгрөг/




Борлуулалтын тоо хэмжээ
/сая.литр/




Цэвэр ашиг
/тэрбум төгрөг/




Бүтээгдэхүүний нэр төрөл
/SKU/




Ажилчдын тоо



Татвар төлөлт
/тэрбум төгрөг/



Ногдол ашиг
/тэрбум төгрөг/



ГОЛЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		нэгтгэсэн санхүүгийн тайлан 2025	нэгтгэсэн санхүүгийн тайлан 2024
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	157,630	171,114
ОРЛОГО ҮР ДҮН			
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	1,318,890	1,327,523
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	261,864	267,057
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	211,656	192,891
БАЛАНС			
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	429,248	459,563
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	651,951	618,993
Нийт хөрөнгө	сая.төг	1,081,200	1,078,556
Нийт өр төлбөр	сая.төг	230,045	283,556
Нийт эздийн өмч	сая.төг	851,155	795,000
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	1,081,200	1,078,556
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	241,880	261,847
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(188,514)	(121,487)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(37,369)	(168,266)
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	1,025	(1,272)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	17,023	(29,178)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	92,974	122,152
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	109,997	92,974
ТАТВАР ТӨЛӨЛТ			
Онцгой албан татвар	сая.төг	249,744	244,810
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	131,731	105,126
Бусад татвар	сая.төг	132,908	124,104
Нийт татвар төлөлт	сая.төг	514,383	474,040
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	162,870	112,099



НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2025 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд нийт 130 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болно.

Тайлант хугацаа	ТУЗ-өөс ногдол ашиг зарласан өдөр	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр	Ногдол ашиг төлөхөөр тогтоосон сүүлийн өдөр	Ногдол ашгийг ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан төлсөн/төлөх өдөр
2025 оны I хагас жил	2025.07.31	65 төг	2025.08.18	2026.02.10	2025.09.18
2025 оны II хагас жил	2026.02.12	65 төг	2026.04.02	2026.08.19	2026.04.30-ны дотор төлнө.
НИЙТ		130 төг			



ТУЗ-ИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТУЗ-ийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга
ПҮРЭВИЙН БАТСАЙХАН



ТУЗ-ийн ердийн гишүүн
СЭН И-ИН



ТУЗ-ийн ердийн гишүүн
БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ



ТУЗ-ийн ердийн гишүүн
БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР



ТУЗ-ийн ердийн гишүүн
КЕННЕТ ЧУ



ТУЗ-ийн ердийн гишүүн
БАТСАЙХАНЫ ГАНТИГ



ТУЗ-ийн хараат бус гишүүн
ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
БАЗАРРАГЧААГИЙН САРАНТУНГАЛАГ



ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн дотоод дүрэм журамд заасан АПУ ХК-ийн ТУЗ-ийн болон түүний охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж ажиллахдаа нийт 10 удаа хуралдаж, 45 тогтоол шийдвэр гаргалаа.

№	Групп компани шийдвэрийн төрөл	Баталсан тогтоолын тоо
1	АПУ ХК ТУЗ-ийн хурлын тогтоол	21
2	АПУ Дэйри ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	3
3	АПУ Трейдинг ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
4	М Би Си Азия Пасифик ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	6
5	СББ Трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
6	Спирт бал бурам ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	4
7	ОХУ-ын Гранд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	1
8	ОХУ-ын Гранд Ист ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	1
9	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эйпиюү трейд ХХК Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	1
	Нийт	45

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81.2-т заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн юм.

ТУЗ-ийн дэргэдэх хороод Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн хариуцсан чиг үүргийн хүрээнд санал, дүгнэлт, шийдвэр гаргаж ажиллав.

ТУЗ-ийн хороо	Хуралдсан тоо	Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс
Аудитын хороо	2	Хорооны дарга Гишүүн Гишүүн	Хараат бус гишүүн Ердийн гишүүн Хараат бус гишүүн	Ж.Үнэнбат Сэн И-Ин О.Одбаяр
Нэр дэвшүүлэх хороо	1	Хорооны дарга Гишүүн Гишүүн	Хараат бус гишүүн Ердийн гишүүн Хараат бус гишүүн	О.Одбаяр П.Батсайхан Ё.Гэрэлчулуун
Цалин урамшууллын хороо	2	Хорооны дарга Гишүүн Гишүүн	Хараат бус гишүүн Ердийн гишүүн Хараат бус гишүүн	Ё.Гэрэлчулуун Ж.Үнэнбат Кеннет Чу



АПУ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

"АПУ групп компани 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан" хэмээн ТУЗ дүгнэсэн болно.



ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2

АПУ ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙГ БҮРЭН БҮРЭЛДЭХҮҮНЭЭР НЬ ХУГАЦААНААС НЬ ӨМНӨ БҮРЭН ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох болсон үндэслэл



СЭН И-ИН (Seng Yi-Ying)



Шелли Коли (Shelly Kohli)

АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн Сэн И-Ин чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул түүний оронд хувьцаа эзэмшигч Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд компаниас Шелли Колиг ТУЗ-д нэр дэвшүүлсэн.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д заасны дагуу ТУЗ-ийг кумулятив аргаар сонгосон бол түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт орох шаардлага үүссэн үед бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэн бүрэлдэхүүнийг сонгох зохицуулалттай.



ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3

АПУ ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ИЙГ СОНГОХ

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 03 сарын 04-ний өдрийн 26/01 тоот шийдвэрээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлсэн.

НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Ердийн гишүүнд нэр дэвшигчид:



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН

1993–1996: Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал
1997–2008: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал
2002–2004: АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
2004–2008: АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал
2008-одоог хүртэл: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч, АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР

Эдийн засагч мэргэжилтэй.
1994–1996: МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш
1999–2001: Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх
2002–2012: Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Ахлах мэргэжилтэн
2012-одоог хүртэл: Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



КЕННЕТ ЧУ

Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй.
1992–1994: Пи Даблью Си, Ахлах аудитор
1997–2003: Роял Ахолд буюу Си Ар Си Ахолд компани, Бүс нутаг хариуцсан захирал, Тэргүүн дэд ерөнхийлөгч
2003–2012: Хайнекен, Бизнес хөгжил хариуцсан захирал
2013–2015: Хайнекен (АПБ, Сингапур, Индочайна, Экспорт), ТУЗ-ийн гишүүн, Бүс нутаг хариуцсан захирал
2015-одоог хүртэл: Хайнекен Азиа Пасифик, Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал
2018-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ШЕЛЛИ КОЛИ

Хуульч, эдийн засагч, улс төр судлаач мэргэжилтэй.

1998–2000: Мумбайн Кроуфорд Бэйли энд Ко, Нийтлэлийн ажилтан

2000–2002: Мумбайн Уадиа Ганди энд Ко, Хуульч

2004: Балтимор хотын орон сууцны удирдах газар, сайн дурын хуульч

2007–2008: Бангалорын Трилигал, Ахлах хуульч

2009–2010: Гургаоны Си Пи Эй Глобал, Рио Тинтогийн Энэтхэгийн салбарт

Ахлах мэргэжилтэн

2010–2012: Бангалорын Женерал Элетрик Интеллигент Платформс, Ахлах зөвлөх

2010–2015: Энэтхэгийн Женерал Электрик, Бангалорын Жи И Энержи менежмент,

хлах зөвлөх

2015–2019: Леви Страусс энд Ко, Өмнөд Ази, Ойрх Дорнод, Хойд Африкийн бүсиг

хариуцсан Ерөнхий зөвлөхийн орлогч

2019–2022: Хиндустан Юнилевер Лтд, Хуулийн албаны дарга

2022-одоог хүртэл: Хайнекен групп, үүнд:

2022–2025: Юнайтед Брьюэрис Лтд, Хууль, комплайнсын захирал

2026-Одоог хүртэл: Хайнекен компани, Ази-Номхон далайн бүсийн

Хууль эрхзүй хариуцсан захирал



БАТСАЙХАНЫ ГАНТИГ

Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй.

2010–2016: Монголбанк, үүнд:

2010–2011: Дотоод аудитор

2011–2012: Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

2012–2016: Ерөнхийлөгчийн туслах

2017–2018: Сангийн яам, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

2018–2025: АПУ ХК, үүнд:

2018–2019: Төслийн удирдагч

2019–2025: Стратеги эрхэлсэн захирал

2020-одоог хүртэл: Дижитал концепт ХХК, Гүйцэтгэх захирал

2024-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ

Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй.

2011–2012: Сангийн яам, Сайдын туслах

2011–2014: Спарк солюшнс ХХК, Санхүү хариуцсан захирал

2017–2021: Голомт банк, Картын хэлтсийн захирал

2021-одоог хүртэл: Шунхлай холдинг ХХК, Бизнес хөгжил хариуцсан захирал

2024-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН

Эдийн засагч мэргэжилтэй.

1981–1989: МУИС, БДС, УАМДИ-д багш

1989–1991: Сайд нарын зөвлөлд референт

1991–1993: Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга

1993–1996: Үйлдвэрийн газрын Өөрчлөн байгуулалтын төвийн захирал

1996–2000: УИХ-ын гишүүн

2000–2006: ЗХАН-ын ЕНБД, "Эх орон-Ардчилал" бүлгийн ажлын албаны дарга

2006–2008: Шадар сайдын ахлах зөвлөх

2008–2016: ХУД, ИТХ-ын ажлын алба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын алба, Нийслэлийн ЗДТГ-ын дарга

2017-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР

Багш, эрх зүйч мэргэжилтэй

1988–1992: Улсын Багшийн Дээд Сургуульд багш

1998–2000: Монгол-Хятадын хамтарсан "Си Эм Эйч" төрийн өмчит компанийн монголын талын Гүйцэтгэх захирал

2002–2005: "МИАТ" ХК-ийн Бээжин дэх төлөөлөгч

2005–2010: Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга

2010–2012: Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх

2012–2016: "Чингис Хаан зочид буудал цогцолбор" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, "Алтай Холдинг" ХХК-ийн Дэд ерөнхийлөгч

2016–2020: "Гашуун Сухайт Автозам" ХХК ТУЗ-ийн гишүүн

2016–2020: "Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн дарга

2016–2019: "Эрдэнэс Монгол" ХХК, Стратеги төлөвлөлт эрхэлсэн Дэд захирал

2012-одоог хүртэл: Ард даатгал ХХК, ТУЗ-ийн гишүүн

2012-одоог хүртэл: Ард Холдинг ХХК, ТУЗ-ийн гишүүн

2017-одоог хүртэл: Монгол шуудан ХК, ТУЗ-ийн гишүүн

2021.11 сар-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ

Эдийн засагч мэргэжилтэй.

1990–2000: Монгол банкинд эдийн засагч, хэлтсийн дарга, Ерөнхийлөгч

1996–2000: Азийн хөгжлийн банк, Монгол дахь төлөөлөгч

2000–2006: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал

2009–2015: Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал

2015–2020: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал, Ерөнхий нарийн бичгийн дарга

2013-одоог хүртэл: АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4

АПУ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ

ҮНДЭСЛЭЛ

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 03 сарын 04-ний өдрийн 26/01 тоот шийдвэрээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлсэн.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Компанийн дүрмийн 7.22.8 дугаар зүйлийг үндэслэн ТУЗ-өөс 2022 оны 05 сарын 06-ны өдрийн 22/07 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн үндсэн цалинг (татвар, хуулиар шаардсан бусад суутгалыг хасаагүй дүн) ТУЗ-ийн дарга 10 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөгөөр тогтоосныг хувьцаа эзэмшигчдийн 2023, 2024, 2025 оны ээлжит хурлуудаар өөрчлөлтгүйгээр баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг дээр дурдсан тогтмол дүнгээр, сар бүр, мөнгөн хэлбэрээр олгон, гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй байхаар шийдвэрлүүлэх санал оруулав.



АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гишүүдийн цалин, урамшуулал

№	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	Нэрс	Сарын үндсэн цалин (төгрөгөөр)
1	ТУЗ-ийн дарга		10,000,000
2	ТУЗ-ийн ердийн гишүүн		6,500,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүн		6,500,000
4	ТУЗ-ийн ердийн гишүүн		6,500,000
5	ТУЗ-ийн ердийн гишүүн		6,500,000
6	ТУЗ-ийн ердийн гишүүн		6,500,000
7	ТУЗ-ийн хараат бус гишүүн		6,500,000
8	ТУЗ-ийн хараат бус гишүүн		6,500,000
9	ТУЗ-ийн хараат бус гишүүн		6,500,000

Тайлбар:

- ТУЗ-ийн гишүүд нь сар бүр тогтмол цалингаар цалинжих бөгөөд цалинг мөнгөн хэлбэрээр олгоно.
- ТУЗ-ийн гишүүдэд гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй.



САНАЛЫН ХУУДСЫН ЗАГВАР

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
26/03 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС №1

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
Регистр эсхүл иргэний бүртгэлийн дугаар:
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо:

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагт цахимаар хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол санал
1	АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах				
2	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг батлах				
3	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг батлах				

Санал өгсөн хувьцаа эзэмшигч.....(гарын үсэг)
Брокер (ҮЦК-аар дамжуулж санал өгсөн бол).....(гарын үсэг, тэмдэг)
Санал өгсөн огноо: 2025 оны сар өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:
Тооллогын комиссын дарга:.....(С.Дөлгөөн)
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....
.....

1. Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 04-р сарын 02-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
2. Цахим хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот) дээр очиж хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар 2026 оны 04 сарын 21-ны өдрийн 18:00 цаг хүртэл урьдчилан санал өгөх боломжтой.
3. Саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
4. Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.



АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС №2

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Регистр эсхүл иргэний бүртгэлийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Кумулятив аргаар өгөх саналын тоо:

(эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржих)

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагт цахимаар хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
1.	Пүрэвийн Батсайхан	
2.	Бүрэнтогтохын Батбаяр	
3.	Кеннет Чу	
4.	Шелли Коли	
5.	Батсайханы Гантиг	
6.	Баярцогтын Гомбо-Эрдэнэ	

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
1.	Ёндон-Ойдовын Гэрэлчулуун	
2.	Одончимэдийн Одбаяр	
3.	Жигжидийн Үнэнбат	

Санал өгсөн хувьцаа эзэмшигч.....(гарын үсэг)

Брокер (ҮЦК-аар дамжуулж санал өгсөн бол).....(гарын үсэг, тэмдэг)

Санал өгсөн огноо: 2025 оны сар өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга:.....(С.Дөлгөөн)

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

.....

1. Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 04-р сарын 02-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
2. Цахим хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХК (Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот) дээр очиж хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар 2026 оны 04 сарын 21-ны өдрийн 18:00 цаг хүртэл урьдчилан санал өгөх боломжтой.
3. Саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
4. Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.



ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ

[АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС]

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУДЫГ БАТЛАХ ТУХАЙ

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан доорх дүгнэлтийг баталсугай.
- 1.1. АПУ групп компани 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгосугай.

Ердийн гишүүн

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.

Хараат бус гишүүн

- 1.
- 2.
- 3.

4. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.ЭРДЭНЭБИЛЭГ



APU COMPANY
Absolute. Pure. Unique.

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

**| ALWAYS
FORWARD**